



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Эзэмшиж буй газрын талбайн хэмжээг  
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшиж буй газрын талбайн хэмжээг өөрчлүүлэх хүсэлт ирүүлсэн 1 (нэг) аж ахуйн нэгжийн газрын талбайн хэмжээг хавсралтад зааснаар баталгаажуулсугай.

2. Эзэмшиж буй газрын талбайн хэмжээ өөрчлөгдөж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/219 дүгээр захирамжийн “Багахангай сүү” ХХК-ны тэжээлийн ургамал тариалах зориулалттай газарт хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД